Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/69/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Назгүл<br>Утас: 99668909 Цахим хаяг:nazgulj@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 4
3. Аудитын тайлан........................................................ 11
3.1 Ерөнхий зүйл........................................................ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 12
3.4 Материаллаг байдал ........................................................ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................................ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................................ 14
3.8 Аудитын гол асуудал ........................................................ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................................ 15
4. Аудитын илрүүлэлт ........................................................ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ЕРТАЙ ТАНАА

2022.02.25 № 236

танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **45,566,572.30** | **43,517,717.30** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 45,566,572.30 | 43,517,717.30 |
| **354** | **Хангамжийн материал** | 25,466,572.30 | 23,417,717.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | - |
| 35420 | Аж ахуйн материал | 6,976,278.00 | 4,973,173.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,064,234.30 | 1,779,784.30 |
| 35450 | Барилгын засварын материал | | - |
| 35460 | Хүнсний материал | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,426,060.00 | 16,664,760.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | 20,100,000.00 | 20,100,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,277,994,188.66** | **4,354,351,788.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,277,994,188.66 | 4,354,351,788.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,272,742,188.66 | 4,349,099,788.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 713,021,490.00 | 762,436,870.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (49,982,590.88) | (79,540,816.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 243,922,989.00 | 357,203,962.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (185,167,497.76) | (182,915,395.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 110,435,595.00 | 121,857,451.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (85,257,394.72) | (85,577,017.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 60,747,236.00 | 66,149,236.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (34,528,214.26) | (42,906,302.86) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 4,462,634,912.10 | 4,530,336,754.10 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (964,717,935.82) | (1,099,578,553.66) |
| 39217 | Ном | 1,633,600.00 | 1,633,600.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,252,000.00 | 5,252,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,513,400.00 | 2,513,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,513,400.00) | (2,513,400.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,252,000.00 | 5,252,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,323,560,760.96** | **4,397,869,505.80** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,323,560,760.96** | **4,397,869,505.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,323,560,760.96 | 4,397,869,505.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 832,907,694.44 | 832,907,694.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 832,907,694.44 | 832,907,694.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,603,430,286.38 | 2,679,974,501.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,768,255,890.24 | 2,605,665,756.38 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (164,825,603.86) | 74,308,744.84 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 887,222,780.14 | 884,987,310.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,323,560,760.96** | **4,397,869,505.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **584,906,252.00** | **737,605,753.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | 620,000.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 620,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 620,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 620,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **584,906,252.00** | **734,475,513.80** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 182,514,999.00 | 270,379,515.80 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 182,514,999.00 | 270,379,515.80 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,704,973.00 | 6,775,738.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,314,055.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,390,918.00 | 6,775,738.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 388,366,500.00 | 459,830,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 378,566,500.00 | 459,830,500.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 9,800,000.00 | |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,319,780.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,319,780.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **749,731,855.86** | **663,297,008.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **749,731,855.86** | **663,297,008.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 725,014,675.86 | 663,297,008.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 277,284,680.00 | 308,306,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 201,666,580.00 | 230,867,933.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,475,600.00 | 48,894,069.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,142,500.00 | 1,723,600.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 26,820,998.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,012,020.00 | 36,532,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,012,020.00 | 25,707,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 2,706,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 2,164,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 541,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 5,412,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,147,240.00 | 7,502,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,370,600.00 | 1,344,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,776,640.00 | 6,158,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,133,000.00 | 45,472,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,096,050.00 | 3,231,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,879,950.00 | 39,495,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,757,000.00 | 2,713,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 33,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,400,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 400,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 400,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 644,150.00 | 4,698,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 644,150.00 | 4,698,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,168,000.00 | 3,852,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,168,000.00 | 3,852,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,681,100.00 | 1,323,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,000.00 | 150,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 438,400.00 | 302,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 206,600.00 | 184,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 96,800.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 479,600.00 | 398,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 45,600.00 | 37,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 109,800.00 | 85,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 363,544,485.86 | 255,151,408.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,080,973.00 | 52,557,893.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 458,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 354,963,512.86 | 202,135,215.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 24,717,180.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,717,180.00 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2,319,780.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,397,400.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(164,825,603.86)** | **74,308,744.84** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(164,825,603.86)** | **74,308,744.84** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 832,907,694.44 | 887,222,780.14 | 2,605,665,756.38 | | 4,325,796,230.96 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **832,907,694.44** | **887,222,780.14** | **2,605,665,756.38** | - | 4,325,796,230.96 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **832,907,694.44** | **887,222,780.14** | **2,605,665,756.38** | - | 4,325,796,230.96 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **832,907,694.44** | **887,222,780.14** | **2,605,665,756.38** | - | 4,325,796,230.96 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **832,907,694.44** | **887,222,780.14** | **2,605,665,756.38** | - | 4,325,796,230.96 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | (2,235,470.00) | | | (2,235,470.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 74,308,744.84 | | 74,308,744.84 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **832,907,694.44** | **884,987,310.14** | **2,679,974,501.22** | - | 4,397,869,505.80 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **392,591,253.00** | **466,606,238.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **392,591,253.00** | **464,095,998.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,704,973.00 | 6,775,738.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,314,055.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,390,918.00 | 6,775,738.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 378,566,500.00 | 459,830,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 378,566,500.00 | 459,830,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,319,780.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,319,780.00 | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **392,591,253.00** | **458,492,938.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **392,591,253.00** | **458,492,938.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **367,874,073.00** | **458,492,938.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 275,864,600.00 | 307,306,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 200,246,500.00 | 229,867,333.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,475,600.00 | 48,894,069.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 1,723,600.00 |
| 210104 | Урамшуулал | | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,142,500.00 | 26,820,998.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,012,100.00 | 36,532,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,045,600.00 | 25,708,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,741,600.00 | 2,706,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,193,300.00 | 2,164,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 548,300.00 | 541,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,483,300.00 | 5,412,300.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,243,600.00 | 8,286,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,370,600.00 | 1,344,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,873,000.00 | 6,942,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,900,600.00 | 21,995,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,070,400.00 | 2,969,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,073,200.00 | 16,225,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,757,000.00 | 2,713,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 88,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 458,300.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 458,300.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 569,000.00 | 1,243,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 569,000.00 | 1,243,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,588,000.00 | 3,852,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,588,000.00 | 3,852,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,731,900.00 | 1,323,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,000.00 | 150,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 438,400.00 | 302,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 219,900.00 | 184,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 96,800.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 517,100.00 | 398,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 45,600.00 | 37,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 109,800.00 | 85,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,505,973.00 | 77,495,738.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,955,973.00 | 76,775,738.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 550,000.00 | 720,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,717,180.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,717,180.00 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2,319,780.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,397,400.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **8,113,300.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **8,113,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **8,113,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 8,113,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 8,113,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | (8,113,300.00) |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,306,000.00 | 307,306,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 230,598,100.00 | 229,867,333.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,025,000.00 | 48,894,069.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,723,600.00 | 1,723,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,959,300.00 | 26,820,998.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,532,800.00 | 36,532,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,708,200.00 | 25,708,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,706,200.00 | 2,706,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,164,900.00 | 2,164,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 541,200.00 | 541,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,412,300.00 | 5,412,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,286,600.00 | 8,286,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,344,600.00 | 1,344,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,942,000.00 | 6,942,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,995,300.00 | 21,995,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,969,300.00 | 2,969,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,601,200.00 | 16,225,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,336,800.00 | 2,713,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000.00 | 88,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,243,400.00 | 1,243,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,243,400.00 | 1,243,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,852,300.00 | 3,852,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,852,300.00 | 3,852,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,323,800.00 | 1,323,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150,400.00 | 150,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200.00 | 302,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,900.00 | 184,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 398,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 37,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 85,000.00 | 85,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,833,300.00 | 78,833,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,333,300.00 | 75,333,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 459,830,500.00 | 459,830,500.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 9.00 | 9.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 9.00 | 9.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 32.00 | 32.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 13.00 | 13.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **29.00** | **29.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8.00 | 8.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 6.00 | 6.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,775,738.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,775,738.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,775,738.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,775,738.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,775,738.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 6,775,738.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 6,775,738.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,775,738.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | |
| 131106 | Төсвийн урамшуулал | |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын зорилго нь: "Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж, мөрдөн, дотоод ажлыг сайжруулж, ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай, байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана" гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 749.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.3 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 45,566.5 | 4,3517.7 | -2,048.8 |
| Үндсэн хөрөнгө | 4,277,994.2 | 4,354,351.8 | 76,357.6 |
| **Нийт хөрөнгө** | **4,323,560.7** | **4,397,869.5** | **74,308.8** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **4,323,560.7** | **4,397,869.5** | **74,308.8** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,323,560.7** | **4,397,869.5** | **74,308.8** |

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 43.5 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 76.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 75.1 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна. Мал амьтад дансанд байгаа 20.1 сая төгрөгийн үлдэгдэл нь нэг бүрийн үнэ 0.3 сая төгрөгийн 40 хуц, 1.4 сая төгрөгийн 5 үхэр, 2.5 сая төгрөгийн 1 үхэр байна.

Ногооннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Засаг даргын тамгын газрын автомашины сэлбэгт 5.0 сая төгрөг, ИТХ-ын автомашины сэлбэгт 16.7 сая төгрөг, хурууны хээ уншигч, камерын системд 2.0 сая төгрөг, Санхүүгийн албаны өрөөний засварт 3.5 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэж бараа материалын дансанд бүртгэжээ.

Тайлант онд сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр сумын Ахмадын ордонд 0.6 сая төгрөгийн аж ахуйн материалыг авч данс бүртгэлд тусгасан байна. Ногооннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 03-н өдрийн 73 дугаар тогтоолоор 2.7 сая төгрөгийн аж ахуйн материал, 0.7 сая төгрөгийн хангамжийн материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4354.3 сая төгрөг болж 76.3 сая төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 8.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.

Тайлант онд Сумын Орон нутаг хөгжүүлэх сангаас 50.5 сая төгрөгөөр ЗДТГ-ын урсгал засвар, 13.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.6 сая төгрөгийн тавилга, 67.7 сая төгрөгийн зам гүүр, аймгийн Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 130.1 сая төгрөгийн Ковш тракторыг үнэгүй хүлээн авсан байна. Мөн 6.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй УАЗ-469 автомашиныг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 122 дугаар тогтоолоор Ногооннуур сумын Эрүүл мэндийн газрын балансаас шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдийн 133 дугаар тогтоолоор элэгдлээ бүрэн нөхөж дууссан 1.1 сая төгрөгийн барилга байгууламж, 23.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийн тавилгыг акталж данснаас хассан байна.

Тайлант хугацаанд өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4397.9 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 74.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Засаг даргын тамгын газрын 2021 оны анх батлагдсан төсөв 337.3 сая төгрөг, тодотгосон төсөв 351.5 сая төгрөг байна.

Анх баталсан төсвийг 14.2 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг нэмж тодотгон баталжээ.

Ногооннуур сумын ИТХ-ын 2021 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн Хуралдааны 23 дугаар тогтоолоор орон нутгийн орлогын давсан хэсгээс 56.8 сая төгрөгийг 17 төсөл арга хэмжээний зардалд хуваарилсан байна. Мөн Засаг даргын нөөц хөрөнгөд 7.0 сая төгрөгийн, Ковид цар тахалд 11.5 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулсан байна.

Тайлант онд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс цалингийн зардлын төсвийг 15.3 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийт 459.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 459.8 сая төгрөгийг зарцуулсан ба төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Нийт төсвийн 66.8 хувийг цалин, 7.9 хувийг НДШ-ийн зардал, 1.8 хувийг тогтмол зардал, 4.7 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.2 хувийг урсгал засварын зардал, 0.8 хувийг дотоод томилолтын зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 17.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ковид-19 цар тахалтай холбоотой зардалд Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулиас 0.2 сая төгрөгийн, Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгээс 0.3 сая төгрөгийн хандивыг, тендерийн баримт бичгийн хураамжийн 0.4 сая төгрөгийн, хагас жилийн мал тооллогод 1.5 сая төгрөгийн, аймгаас ковид-19 цар тахалд өгсөн 2.5 сая төгрөгийг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 0.5 сая төгрөгийг эмзэг бүлгийн хүүхдүүдэд, Ахмадын ордны түрээсийн орлого 1.4 сая төгрөгийг, нийт 6.8 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 459.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу 10.8 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 4.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 459.8 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 459.8 сая төгрөгийн 146 мэдээллийг ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 97.9 хувьтай байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, түлш халаалтын зардлаас 1.3 сая төгрөгийг Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зарцуулсан, 1.8 сая төгрөгийг батлагдсан

төсвөөс хэтрүүлэн цалингийн зардалд зарцуулсан зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлтийг Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 10-р сарын 07-ны өдрийн 97 тоот албан бичгээр ирүүлжээ.

Зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг давтан шалгаж үзэхэд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан зөрчлийг арилгаж албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.9 сая төгрөгийн зөрчил илэрч 14.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 14.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 459.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үүнээс Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу 10.8 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 4.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;” 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Ногооннуур сумын ЗДТГ | 1 | 14.9 | | | | | 1 | 14.9 | | |